

ГААЛИЙН АСУУДЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ,
ХАРИЛЦАН ТУСЛАХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ
ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН
ХЭМЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэж нэрлэгдэх/,

Хоёр улсын найрсаг, сайн хөршийн харилцааг гаалийн салбарт хамтран ажиллах замаар хөгжүүлэхийг хүсч,

Гаалийн байгууллагуудын хамтын ажиллагааны шугамаар хоёр орны хоорондын зорчигч, бараа тээврийн харилцааг хөхүүлэн дэмжиж, хөнгөвчлөхийг өрмөлзэж,

Гаалийн хуулийн зөрчил нь эдгээр орны эдийн засаг, нийгмийн болон санхүүгийн ашиг сонирхолд хохирол учруулж байгааг анхааран үзэж,

Гаалийн байгууллагуудын хамтын ажиллагаа нь гаалийн зөрчилтэй хийх тэмцлийг илүү үр дүнтэй болгоно гэдэгт итгэж,

Дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрийн зорилгод:

1. "Гаалийн хууль" гэдэгт Гаалийн байгууллагуудаас мөрдүүлж буй хэрэгжүүлж буй бараа оруулах, гаргах, дамжуулан өнгөрүүлэхтэй холбогдох эрх зүйн хэм хэмжээг ойлгоно;

2. "Гаалийн байгууллага" гэдэгт Бүгд Найрамдах Хятад Ард Улсад - Гаалийн ерөнхий газар, Монгол Улсад - Улсын гаалийн ерөнхий газрыг ойлгоно;

3. "Гаалийн зөрчил" гэдэгт Гаалийн хууль зөрчсөн буюу зөрчихийг завдсан аливаа үйлдлийг ойлгоно.

Хоёрдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага энэхүү Хэлэлцээрийн хүрээнд хоёр орны хоорондын худалдаа, хүн солилцоог хөхүүлэн дэмжих үүднээс гаалийн ажлын арга туршлага, дүрэм, журам солилцох, гаалийн үйл ажиллагааг зохион байгуулах талаар харилцан туслалцаа үзүүлэх замаар хамтын ажиллагаагаа эрчимжүүлнэ.

Гуравдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага дараах асуудлаар мэдээлэл солилцоно. Үүнд:

1. Үндэсний эдийн засаг болон олон улсын худалдаанд Гаалийн байгууллагын гүйцэтгэх үүрэг;

2. Улсын хилээр орж, гарч байгаа бараа, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, шуудан илгээлт, бусад зүйлд тавих гаалийн хяналтын арга;

3. Гаалийн тусгай бүсийн бараанд гаалийн хяналт тавих арга;

4. Уялдуулсан систем, үнэлгээний аргачлалыг хэрэгжүүлэх талаар хуримтлуулсан туршлага;

5. Контрабандын үйлдлийн гол шинж, нуух арга, контрабандыг таслан зогсоох арга, тэдгээрийн үр дүн;

6. Гаалийн хууль, дүрэм, журам;

7. Гаалийн удирдлагын шинэчлэлт;

8. Гаалийн ажилд компьютер болон орчин үеийн бусад цэвшилтэт техник хэрэгсэл хэрэглэж байгаа байдал;

9.Харьяа гаалийн байгууллага байгуулсан байдал,гаалийн ажилтнуудын сургалт, давтан сургалт;

10.Олон улсын байгууллага дахь үйл ажиллагаа болон олон улсын конвенцийг хэрэгжүүлэх талаар хуримтлуулсан туршлага;

11.Хэлэлцэн тохирогч хоёр Талын харилцан сонирхож буй бусад асуудал.

Дөрөвдүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага энэхүү Хэлэлцээрийн үйлчлэх хүрээнд гаалийн мэргэжилтэн болон сургалтын төвийн багш нарыг харилцан солилцож гаалийн ажилн талаарх мэдээллийг солилцоно.

Тавдугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын Гаалийн байгууллага,Хэлэлцэн тохирогч нөгөө Талын Гаалийн байгууллагын хүсэлтээр, өөрийн эрх хэмжээ, хүч бололцооны хүрээнд дараах зүйлсэд тодорхой хугацаагаар тусгай хяналт тавин ажиллаж, тэдгээрийн талаар хүсэлт гаргасан Талын Гаалийн байгууллагад мэдээлэл явуулна.Үүнд:

1.Хүсэлт гаргасан Талын гаалийн дүрэм, журмын зөрчилд холбогдон сэжиглэгдэж байгаа этгээд улсын хилээр орж, гарч байгаа зорчигчдын дунд байвал;

2.Гаалийн зөрчилд холбогдон сэжиглэгдэж байгаа гэж хүсэлт гаргасан Талын Гаалийн байгууллагаас мэдэгдсэн тодорхой бараа, эд зүйл;

3.Хүсэлт гаргасан Талын гаалийн хуулийн зөрчилд холбогдон сэжиглэгдэж байгаа автомашин, нисэх онгоц болон тээврийн бусад хэрэгсэл.

Зургадугаар зүйл

Хэлэлцэн тохирогч нэг Талын Гаалийн байгууллага, өөрийн санаачилгаар буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Талын Гаалийн байгууллагын хүсэлтээр, гаалийн үнэлгээний зөрчил болон гаалийн бусад зөрчил, ялангуяа, мансууруулах болон сэтгэгч нөлөөт бодис, зэвсэг, галт хэрэгсэл, тэсрэх бодис болон түүх, урлаг, соёл, археологийн үнэ цэнэ бүхий эд зүйлтэй холбогдсон зөрчлийг илрүүлэхэд тустай мэдээллийг нөгөө Талд өгч болно.

Долдугаар зүйл

Хоёр улсын хилээр орж, гарч байгаа бараа нь гаалийн эрх бүхий байгууллага, зөвшөөрөгдсөн замаар нэвтрэх явдлыг хангах үүднээс Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага холбогдох арга хэмжээг авч ажиллана. Энэ зорилгоор, Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага хоёр улсын залгаа хилийн дагуу байрладаг харьяа гаалийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрийн ажиллах цагийг харилцан мэдэгдэнэ.

Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллагын зөвшөөрснөөр тэдгээрийн харьяа хилийн гаалийн байгууллагууд гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг хөнгөвчлөх боломж болон харилцан сонирхох бусад асуудлаар шаардлагатай үед уулзалт зохион байгуулж болно.

Наймдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийн дагуу цамжуулсан буюу олж авсан аливаа мэдээ, бичиг баримт, эсвэл бусад мэдээллийг нууцад тооцож, тэдгээрийг энэхүү Хэлэлцээрт заасан зорилгоор, түүнийг гаргаж өгсөн Гаалийн байгууллагаас тогтоосон хязгаарлалтын хүрээнд ашиглана. Тэдгээр нь түүнтэй ижил, мэдээ, бичиг баримт, эсвэл бусад мэдээллийг тухайн оронд хэрхэн нууцлан хамгаалдгийн адилаар нууцлан хамгаалагдана.

Бсдүгээр зүйл

Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын Гаалийн байгууллага хүсэлтийг биелүүлэх явдал нь тухайн Хэлэлцэн тохирогч Талын бүрэн эрхт болон аюулгүй байдал, үндэсний бусад чухал эрх ашигт хохирол учруулж болзошгүй, эсвэл түүний аливаа улсын буюу хувийн үйлдвэрийн газрын хууль ёсны худалдааны ашиг сонирхолд нийцэхгүй, эрх зүйн хүчин төгөлдөр заалтуудтай зөрчилдөж байна гэж үзвэл тухайн хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж, эсвэл тодорхой нөхцөл, шаардлага тавьсны үндсэн дээр биелүүлж болно.

Аравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогцууль Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага уулзалт зохион байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд тэргүүн нарны хэмжээний уулзалтыг хоёр улсад ээлжлэн хийж болно. Уулзалтын хугацаа, хэлэлцэх асуудлыг Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага боломжийн хэрээр урьдчилан тохиролцоно.

Арван нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрт заасан туслалцаа, хамтын ажиллагааг Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллагууд хамгийн эрчимтэй хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага хоёр Талд тохиромжтой гуравлагч орны хэлээр шууд харилцаж болно.

Арван хоёрдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдож гарах зардлын төлбөрийг хэрхэх тухай Хэлэлцэн тохирогч хоёр Талын Гаалийн байгууллага тусгайлан тохиролцоно.

Арван гуравдугаар зүйл

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талууд түүнийг хүчинтэй болгох талаар хууль зүйн бүхий л шаардлагыг бие-лүүдсэн тухай сүүлийн мэдэгдлээс хойш ерөн /90/ өдрийн дараа хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээр нь хугацаагүй байгуулагдсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь түүнийг хүчингүй болгох тухай нөгөө Талдаа дипломат шугамаар аль ч үед бичгээр мэдэгдэж болно. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчингүй болгох тухай мэдэгдлийг нөгөө Тал хүлээн авснаас хойш зургаан /6/ сарын дараа хүчингүй болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1993 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр Улаанбаатар хотноо хятад, монгол, англи хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийг тайлбарлахад санал зөрвөл англи хэл дээрх эх бичвэрийг баримтална.

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЭРХ
ОЛГОСНЫ ДАГУУ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРААС ЭРХ ОЛГОСНЫ
ДАГУУ

刘文杰

